



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар

16/01

Номгон

Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн  
ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2-ын “ж”, Хот байгуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.1 дэх заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит бус XVI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын захиалгаар “Хот байгуулалтын хөгжлийг дэмжих төв” ХХК-ний гүйцэтгэсэн Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Шинэ суурьшлын бүсийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж, инженерийн шугам сүлжээ, дэд бүтцээр хангах, барилга байгууламжийг төлөвлөн барих асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргын үүрэг гүйцэтгэгч /Т.Эрдэнэбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА




Ц.ОТГОНБАЯР

1190016



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын  
2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн ХҮИ  
хуралдааны 16/01 дүгээр тогтоолын хавсралт

## БАЯНХОНГОР СУМЫН ШИНЭ СУУРЬШЛЫН БҮСИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ



### Байршилын схем

Шинэ суурьшлийн бүс байгуулах хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах талбай нь аймгийн нисэх онгоцны буудлын зурвасын баруун талд Говь-Алтай аймгаас ирэх замын урд талд байрлана.

### Төлөвлөлт хийсэн талбай 320 га

Төлөвлөлтөөр 2300 өрхийн 8000 орчим хүн ам суурьших ба Засаг захиргаа, нийгмийн үйлчилгээний барилга байгууламж, амины орон сууц, таун хаус, нийтийн орон сууцны барилга байгууламжууд, цэцэрлэгт хүрээлэн, спорт амралтын талбай, инженерийн дэд бүтцийн эх үүсвэр, түүний шугам сүлжээний төлөвлөлтийг хийж гүйцэтгэсэн.